



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
И-мэйл: info@mrpm.gov.mn, Вэбсайт: mrpm.gov.mn

2021. 01. 21 № 1/227
танай 2021. 01. 05 ны № 03/04 -Т

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМАНД**

Танай 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03/04 тоот албан бичгийн дагуу 2020 оны дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа бүтээгдэхүүний биелэлт болон байгууллагын худалдан авалтын тайланг жилийн эцсийн байдлаар боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2.. хуудастай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

ЗАХИАЛАГЧИЙН 2020 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2020 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардал, “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг”-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх нийт 11 нэр төрлийн 625.4 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/101 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан ба нийт 9 нэр төрлийн 320.6 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулан ажилласан. “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг”-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх “Геофизикийн чичирхийллийн судалгааны анхдагч мэдээлэл, соронзон туузыг унших, завсрын боловсруулалт хийх, хүндийн хүч, соронзон судалгааны мэдээллийг бүрэн боловсруулах зураг зохиох программ хангамж, тоног төхөөрөмж”-ийн 2 дахь үе шатны тендерт 300.0 сая төгрөг төсөвлөн 2020 оны төлөвлөгөөнд батлуулсан боловч (Ковид-19) цар тахалтай холбоотойгоор орлого бүрдээгүй тул хойшлуулах арга хэмжээг авч төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан.

Тендер шалгаруулалтын журмаар ангилан үзэхэд нээлттэй тендер шалгаруулалт 2, зөвлөхийн бусад үйлчилгээ 2, харьцуулалтын аргаар 2, шууд худалдан авалтаар 3 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан.

1. Бичгийн цаас нийлүүлэх тендер -Харьцуулалтын арга /2 удаа зарласан./
2. Плоторын цаас худалдан авах- Шууд худалдан авалт
3. Принтерийн хор нийлүүлэх тендер- Харьцуулалтын арга
4. Бичиг хэргийн бусад материал худалдан авах- Шууд худалдан авалт
5. Шатахуун нийлүүлэх тендер- Нээлттэй тендер шалгаруулалт
6. УИТ-85М багажийн оношилгоо, засвар, үйлчилгээ- Харьцуулалтын арга
7. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ- Шууд худалдан авалт
8. Харуул хамгаалалтын хөлс- Нээлттэй тендер шалгаруулалт
9. Даатгалын үйлчилгээ – Харьцуулалтын арга

Төлөвлөгөөнд тусгагдсан 9 нэр төрлийн 320.6 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг зохион байгуулж ажиллахаас жилийн эцсийн байдлаар гэрээ байгуулагдсан 5, хугацаа хойшлуулсан 1, шууд худалдан авалтаар 3, үнэлгээний хороо байгуулагдсан 5 арга хэмжээг тус тус хуулийн дагуу зохион байгуулж ажилласан байна. Дээрх арга хэмжээг зохион байгуулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан, аль нэг аж ахуй эрхлэгчдэд давуу эрх олгоогүй бөгөөд тендертэй холбоотой маргаан, гомдол тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдээс ирүүлээгүй болно.

Байгууллагын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулан, тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайт, өдөр тутмын сонинд нийтлэх, шилэн дансанд явц, үр дүнг тухай бүр нийтлэн дараах чиг үүргийг мөрдлөг болгон ажиллав.

Үүнд:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдлөг болгох,
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт

заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулах,

3. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан, аль нэг аж ахуй эрхлэгчдэд давуу байдал олгохгүй байх, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах,
4. Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилга үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайтад нийтлэх,
5. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт”-ийн хэрэгжилтийг хангах,
6. Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж байх зэрэг болно.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу www.tender.gov.mn цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлд нийтэлж, тендерийн үр дүнг сар бүр Шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээлэн, ил тод байдлыг ханган ажиллаж байна. АМГТГ-ын худалдан авах ажиллагааны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

ЗАХИАЛАГЧИЙН 2020 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

/Жилийн эцсийн байдлаар/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг /сая төгрөг/	Эрх шилжүүлэх эсэх /ТЕЗ-ийн нэр/	Гэрээний дүн /сая төгрөг/	Гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаар	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа						Уламжлалт /цахимаар зарласан эсэх	Тайлбар тодруулга
							Үнэлгээний хороо байгуулсан огноо	tender.gov.mn сайтad тендерийн урилга нийтэлсэн огноо	Сонин хэвлэлд тендерийн урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	tender.gov.mn-д нийтэлсэн огноо	Гэрээ дуусгаж дүгнэсэн огноо		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Уул уурхайн яам													
2	Ашигт малтмал, газрын тосны газар													
Бичиг хэрэг														
2.1	Бичгийн цаас	15.00	АМГТГ	14.55	"Төгс дардас" ХХК 2020/40	ХА	2020/01/13	2020/02/26 2020/05/21	2020/02/26 2020/05/21	2020/06/12	2020/05/21	2020/12/26	цахим	Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу бүх тендерээс татгалзсан. Тендерийг 2020/05/21-ний өдөр дахин зарлаж "Төгс дардас" ХХК шалгарч 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 2020/40 тоот гэрээг байгуулсан.
2.2	Плоторын цаас	2.50	АМГТГ	2.50		ШХА								Хуульд заасан босго үнийг үндэслэн 2,500.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
2.3	Принтерийн хор /өнгөт, хар/	15.00	АМГТГ	8.60	"Дижитал сервис" ХХК 2020/26	ХА	2020/01/13	2020/02/26	2020/02/26	2020/03/20	2020/02/26	2020/12/26	цахим	Тендер "Дижитал сервис" ХХК шалгарч 2020/26 тоот гэрээ байгуулсан.
2.4	Бичиг хэргийн бусад материал	7.36	АМГТГ	7.36		ШХА								Хуульд заасан босго үнийг үндэслэн 7.36 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
2.5	Шатахуун	110.20	АМГТГ	82.53	"Петростар" ХХК 2020/46	НТШ	2020/05/18	2020/06/04	2020/06/04	2020/07/17	2020/06/04	2021/07/31	цахим	Тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулж, 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдөр зарлаж "Петростар" ХХК шалгарч 2020/46 тоот гэрээг байгуулсан.
	Дүн	150.06		115.54										
Эд хогшил, урсгал засварын зардал														

